

Long

Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуйн яамны “Амьтан болон ургамлын хорио цээрийн газар”-с мэдэгдэж байна.

Гадны улсаас хиам, зайдас зэрэг малын гаралтай бүтээгдэхүүн, жимс ногоо, амьд цэцэг болон үр зэрэг ургамлыг Японд авчрах нь хориотой.

Мөн онгоцны хоолыг авч явахыг хориглодог тул, онгоцноос буухдаа, идэлгүй үлдсэн хоолоо авч буухгүй байхыг хүсье.

Гаалийн үзлэгт орохоос өмнө малын гаралтай бүтээгдэхүүн авч яваа бол “Амьтны хорио цээрийн хэсэг”-т, эсвэл ургамал авч яваа бол “Ургамлын хорио цээрийн хэсэг”-т тус тус очино уу.

Түүнчлэн гадаадад амьтантай харилцсан, Японд мөн мал амьтадтай харьцахыг төлөвлөж байгаа бол “Амьтны хорио цээрийн хэсэг”-т очино уу.

Хэрэв малын болон ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг хууль бусаар авчирсан бол хуулийн дагуу 3 хүртэл жил хорих, эсвэл 3 сая хүртэлх иений торгууль ногдуулна. Байгууллагын хувьд 50 сая иен хүртэлх торгууль ногдуулах боломжтой тул анхааралдаа авна уу.

Түүнчлэн импортын зөвшөөрөлгүй малын гаралтай бүтээгдэхүүн авч явбал хилээр нэвтрүүлэхгүй байж болно.

Ази болон дэлхийн улсуудад тархаж байгаа гахайн Африкийн мялзан өвчин зэрэг малын халдварт өвчин, цитрусын жимсний ялаа зэрэг хортон шавьжийг Японд оруулахгүй байхад хамтран ажиллахыг хүсье.

Short

Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуйн яамны “Амьтан болон ургамлын хорио цээрийн газар”-с мэдэгдэж байна.

Гадны улсаас хиам, зайдас зэрэг малын гаралтай бүтээгдэхүүн, жимс ногоо, амьд цэцэг зэрэг ургамлыг Японд авчрах нь хориотой.

Мөн онгоцны хоолыг авч явахыг хориглоно.

Малын гаралтай бүтээгдэхүүн авч яваа бол “Амьтны хорио цээрийн хэсэг”-т, эсвэл ургамал авч яваа бол “Ургамлын хорио цээрийн хэсэг”-т тус тус очино уу.

Амьтны болон ургамлын хорио цээрийн газарт шалгуулахгүй нэвтэрсэн тохиолдолд торгууль ногдох боломжтой тул анхаарна уу. Мөн импортлох зөвшөөрөлгүй малын гаралтай бүтээгдэхүүн авч явбал хилээр нэвтрүүлэхгүй байж болно.

Дэлхийн улсуудад гарч буй малын халдварт өвчин, ургамлын хортон шавьж зэргийг Японд оруулахгүй байхад хамтран ажиллахыг хүсье.